

**МОНГОЛ УЛСЫН 2022 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ, НИЙГМИЙН ДААТГАЛЫН
САНГИЙН 2022 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ, ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН
САНГИЙН 2022 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ, ИРЭЭДҮЙН ӨВ САНГИЙН 2022 ОНЫ
ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙГ ГУРАВ ДАХЬ ХЭЛЭЛЦҮҮЛЭГТ
БЭЛТГЭСЭН ТАЛААРХ ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ТАНИЛЦУУЛГА**

2021 оны 11 дүгээр
сарын 10-ны өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2021 оны 9 дүгээр сарын 30-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2022 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2022 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2022 оны төсвийн тухай, Ирээдүйн өв сангийн 2022 оны төсвийн тухай хуулийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын чуулганы 2021 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар хийж, гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Төсвийн байнгын хороо 2021 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн хуралдаанаараа дээрх хуулийн төслүүдийн гурав дахь хэлэлцүүлгийг хийлээ.

Нэгдсэн хуралдаанаар хуулийн төслүүдийн хоёр дахь хэлэлцүүлгийг хийх үед дэмжигдсэн зарчмын зөрүүтэй саналын томьёолол, мөн Төрийн байгуулалтын байнгын хороогоор хэлэлцсэн Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг нэгтгэсэн төслийн дагуу холбогдох өөрчлөлтийг төсвийн төсөлд болон холбогдох хавсралтуудад тусгасан төслийг Байнгын хорооны хуралдаанаараа хэлэлцүүлээ.

Байнгын хорооны хуралдаанаар төсвийн төслийн гурав дахь хэлэлцүүлгийг хийх үед Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.1 дэх хэсэгт заасныг үндэслэн Улсын Их Хурлын зарим гишүүдээс хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төсөвт өртөг, санхүүжих дүнг өөрчлөхгүй, агуулга, зарчмыг алдагдуулахгүйгээр арга хэмжээний нэр, хүчин чадал, байршилтай холбоотой залруулга хийх санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул эдгээр саналыг төсвийн төсөлд тусгасан болно.

Монгол Улсын Засгийн газраас өргөн мэдүүлсэн төсвийн төсөлд дараах өөрчлөлтүүд орохоор байна. Үүнд:

1. Үндсэн хуулийн цэцийн даргын урсгал зардлыг **300.0 сая** төгрөгөөр, Улсын Их Хурлын даргын урсгал зардлыг нийт **4,952.8 сая** төгрөгөөр, Хүний эрхийн үндэсний комиссын урсгал зардлыг **1,664.6 сая** төгрөгөөр, Соёлын сайдын урсгал зардлыг **1,400.0 сая** төгрөгөөр, Санхүүгийн зохицуулах хорооны урсгал зардлыг **1,427.5 сая** төгрөгөөр, Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын урсгал зардлыг **1,000.0**

сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлэх, Шүүхийн сахилгын хорооны урсгал зардлыг **1,738.0 сая төгрөгөөр** тооцож төсөлд тусгах;

2.Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн дүнд холбогдох өөрчлөлтийг хийж хөрөнгө оруулалтын зардлыг **81.1 тэрбум төгрөгөөр** нэмэгдүүлэх;

3.Хөрөнгийн зардалд өөрчлөлт орсонтой уялдуулан Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын урсгал зардлыг **500.0 сая төгрөгөөр**, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын урсгал зардлыг **250.0 сая төгрөгөөр**, Соёлын сайдын урсгал зардлыг **200.0 сая төгрөгөөр** нэмэгдүүлж, Хууль зүй, дотоод хэргийн сайдын урсгал зардлыг **2,000.0 сая төгрөгөөр** бууруулах;

4.Төсвийн ерөнхийлөн захирагч нарын зарцуулах зардалд өөрчлөлт орсонтой холбогдуулан арилжааны банкуудад олгох зээлийн хүүгийн татаасыг **91.0 тэрбум төгрөгөөр** бууруулах;

5.Улсын төсвөөс хариуцах тусламж, үйлчилгээний зардалд тусгагдсан санхүүжилтээс **163.7 тэрбум төгрөгийг** Төрөөс эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг нь хариуцах иргэдийг улсын төсвөөс төлөх шимтгэлийн зардалд шилжүүлэх;

6.Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийн төслийн 2 дугаар хавсралтад тусгагдсан **7,569.3 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 5 төсөл**, арга хэмжээний төсөвт өртгийг **2,769.3 сая төгрөгөөр** бууруулж **172,397.2 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 38 төсөл**, арга хэмжээний төсөвт өртгийг **108,836.1 сая төгрөгөөр** нэмэгдүүлэх;

7.Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийн төслийн 2 дугаар хавсралтад тусгагдсан нийт **46 төсөл** арга хэмжээний нэр, хүчин чадал, байршилд холбогдох өөрчлөлтийг оруулах;

8.Урсгал болон хөрөнгийн зардалд өөрчлөлт орсонтой холбогдуулан төсвийн ерөнхийлөн захирагч нарын төвлөрүүлэх орлого, зарцуулах зардал, орон нутгаас улсын төсөвт төвлөрүүлэх орлого, орон нутагт улсын төсвөөс өгөх татаасын хэмжээнд холбогдох өөрчлөлтийг тусгах;

9.Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт орохтой холбогдуулан 2022 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагч нарын хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх үр дүн, зарцуулах зардал, төвлөрүүлэх орлогын дүнд холбогдох өөрчлөлтүүдийг тус тус тусгасан болно.

Монгол Улсын Засгийн газраас өргөн мэдүүлсэн төсвийн төсөлд дээрх өөрчлөлтүүдийг тусгаснаар зарлагын болон алдагдлын дүнг нэмэгдүүлэхгүй байх хуулийн шаардлагыг хангасан болно.

Төслийн эцсийн хувилбараар Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт орлого ба тусламжийн дүн **16,415.1 тэрбум төгрөг**, нийт зарлага ба цэвэр зээлийн дүн **18,158.7 тэрбум төгрөг**, тэнцвэржүүлсэн орлогоор тооцсон тэнцлийн алдагдал **2,387.1**

тэрбум төгрөг буюу дотоодын нийт бүтээгдэхүүний 5.1 хувьтай тэнцүү байхаар тооцлоо.

Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь Монгол Улсын 2022 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2022 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2022 оны төсвийн тухай, Ирээдүйн өв сангийн 2022 оны төсвийн тухай хуулийн төслийн эцсийн хувилбарыг нэгдсэн хуралдаанд танилцуулж, төслүүдийг батлуулах нь зүйтэй гэж үзэж, хуулийн төслүүдийн эцсийн хувилбар болон холбогдох хавсралт, тооцоог Та бүхэнд тараасан болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2022 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2022 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2022 оны төсвийн тухай, Ирээдүйн өв сангийн 2022 оны төсвийн тухай хуулийн төслийг гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх тус Байнгын хорооны танилцуулгыг хэлэлцэн, төслүүдийн гурав, дөрөв дэх хэлэлцүүлгийг хийж, хуулийн төслүүдийг баталж өгнө үү.

Анхаарал тавьсанд баярлалаа.

ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

A handwritten signature in black ink is written over a red rectangular official stamp. The stamp contains Mongolian text and a date. The signature is written in a cursive style.

Ч.ХҮРЭЛБААТАР